



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Улаанбурхан өвчний болзошгүй дэгдэлтээс
сэргийлэх зарим арга хэмжээний тухай

Дэлхийн хэмжээнд 2018 онд Улаанбурхан өвчний 229,068 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд одоогоор Энэтхэг, Тайланд, Бангладеш, Филлипин, Малайз, БНХАУ, Гүрж, Серб, Итали, ОХУ зэрэг орнуудад Улаанбурхан өвчний дэгдэлт гарч, манай улсад зөөвөрлөгдөн орж ирэх өндөр магадлал байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09 тоот албан даалгаварыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбурхан өвчний болзошгүй дэгдэлтээс сэргийлэх арга хэмжээг дүүргийн хэмжээнд зохион байгуулж удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг НЭМТҮЭО дарга /Б.Лувсанням/-д даалгасугай.

2. Эмчилгээ эрхэлсэн орлогч даргад даалгах нь:

- 2.1. Халдвараас сэргийлэх, халдвар хяналтын дэглэмийг баримтлах, хяналт тавих, үйлчлүүлэгчийн урсгал хөдөлгөөнд байнга зохицуулалт хийх
- 2.2. Яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлэхээр ирсэн халууралт тууралтат хам шинж бүхий сэжигтэй тохиолдлыг эрэмбэлэн ангилах, тусгаарлах, хөтөч сувилалчийг 2019.02.01-ний өдрөөс ажиллуулан, лабораторийн сорьц авч ХӨСҮТ-д хүргүүлэх
- 2.3. Тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангаж сорьц шинжлэгдэхүүн авах материал хэрэгсэл, яаралтай тусламжийн эм тарианы нөөцийг бүрдүүлэн ажиллах

3. Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгах нь:

- 3.1. Цочмог халууралт тууралтат хам шинж, улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдол бүрийг бүртгэж, мэдээлэх, лабораторийн шинжилгээнд сорьц авах
- 3.2. Улаанбурхан, гахайн хавдар, улаанууд өвчний эсрэг товлолын дархлаажуулалтаас хоцорсон хүүхдийн судалгааг гарган нөхөн дархлаажуулах арга хэмжээг 2019.02.15-ны дотор зохион байгуулах
- 3.3. Харьяа хүн амын дунд болон амбулаториор үйлчлүүлэгчдийн дунд Улаан бурхан өвчнээс сэргийлэх, товлолт дархлаажуулалтанд бүрэн хамрагдах талаар сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах

- 3.4. ЭМС-ын 2019 оны 09 тоот албан даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг сар бүрийн 15,30-нд тархвар судлаач Н.Ганчимэгт ирүүлж байх
4. Эрсдэлт бүлгийн хүн амд шаардагдах А амин дэмийн тооцоо судалгааг гарган НЭМГ-т хүргүүлэх, Улаанбурхан өвчний оношилгоо, эмчилгээний талаар ЭМТ,ӨЭМТ-ийн эмч нарт сургалт зохион байгуулахыг хүүхэд өсвөр үеийн асуудал хариуцсан ерөнхий мэргэжилтэн /Т.Энхээ/-д үүрэг болгосугай.
 5. Улаанбурхан өвчний талаар мэдээлэл сэрэмжлүүлэг, сурталчилгааг олон нийтэд өргөнөөр сурталчилахыг сургалтын арга зүйч /Ч.Гүнчинхорлоо/-д үүрэг болгосугай.
 6. Албан далгаварын хэрэгжилтийг 14 хоног тутам нэгтгэн гаргаж НЭМГ-т хүргүүлж байхыг тархвар судлаач /Н.Ганчимэг/-т даалгасугай.
 7. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээнийн чанарын албаны дарга /Н.Оюунмэд/-д даалгасугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ